



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2017 оны 10 дугаар сарын 25

№ 76

Мандалговь хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Луус сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрлын аудит хийх явцад хоолний технологийн картыг батлуулж мөрдөөгүй, батлагдсан жишиг хэмжээг мөрдөөгүй нийт 1,585,695.00 / нэг сая таван зуун наян таван мянга зургаан зуун ерөн тав/ төгрөгийн хүнсний материалыг хяналтгүй зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2017 оны 02 сарын 23-ны өдрийн А/74 тоот тушаалаар баталсан “Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмж жишиг хэмжээ”-г зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрүүзүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох санаалыг холбогдох байгууллагыг тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжсуулэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.7-т /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтанааргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Нормативт зардлыг хяналтгүй зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоох, цаашид холбогдох журмыг мөрдөж ажиллах;

0000000105

2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг Луус сумын Эрүүл мэндийн төвийн дарга Г.Наранжаргал, нягтлан бодогч Б.Доржханд нарт хариуцуулав.

<p>АЛБАН ШААРДЛАГЫГ ЕГСӨН: АХЛАХ АУДИТОР Б.ГАНТУЯА ДАРГА НЯГТЛАН БОДОГЧ</p> <p>4817144213 ЗЮА0039 9033475</p>	<p>АЛБАН ШААРДЛАГЫГ ЗӨВШӨӨРСӨН: Г.НАРАНЖАРГАЛ Б.ДОРЖХАНД</p> <p>33E0001 9033319</p>
---	---

---

<sup>1</sup> Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанд ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэ/